

**ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2024 оны 08 дугаар сарын 20-ны өдөр, Мягмар гараг*

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>1-3</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>4-19</i>

---

1. “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ/	4-12
2. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/	12-19

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит бус чуулганы  
Инновац, цахим бодлогын байнгын хорооны 08 дугаар сарын 20-ны  
өдөр /Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга Ж.Золжаргал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 13 гишүүнээс 8 гишүүн хүрэлцэн ирж, 61.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 50 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Галбадрах.

Хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал оролцов.

**Нэг. “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Д.Цолмон, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Л.Балчинлуvsан, мөн газрын Салбарын нэгдсэн бодлогын хэлтсийн дарга О.Энхмөнх, Бодлого, төсөөллийн хэлтсийн дарга Б.Мөнх-Эрдэнэ, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын зөвлөх П.Мөнхбат, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны Харилцаа холбооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга С.Цагаанхүү, мөн яамны Нийтийн мэдээллийн дэд бүтцийн хэлтсийн дарга Д.Батбаяр, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга П.Дэлгэрмаа, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын дарга П.Батбаатар, Кибер аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны дарга Ч.Золбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Инновац, цахим бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Бат-Эрдэнэ, референт П.Болорцэцэг нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1 дүгээр заалттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхбатын тавьсан асуултад Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү, Кибер аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны дарга Ч.Золбаяр нар хариулж, тайлбар хийв.

Төслийн 2 дугаар заалттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төслийн 3 дугаар заалттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэнгийн тавьсан асуултад Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү хариулж, тайлбар хийв.

Төслийн 4 дүгээр заалттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

*Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхбат Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.*

*Уг асуудлыг 16 цаг 24 минутад хэлэлцэж дуусав.*

***Хоёр.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Б.Цолмон, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын зөвлөх П.Мөнхбат, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Харилцаа холбооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга С.Цагаанхүү, мөн яамны Нийтийн мэдээллийн дэд бүтцийн хэлтсийн дарга Д.Батбаяр, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга П.Дэлгэрмаа, Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, ахлах шинжээч Э.Цолмон, мөн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, мэргэжилтэн Г.Мөнхзул, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Төсвийн зарлагын хэлтсийн шинжээч Э.Номин-Эрдэнэ, Монгол Улсын ерөнхий аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын дарга П.Батбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Инновац, цахим бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Бат-Эрдэнэ, референт П.Болорцэцэг нар байлцав.

Төсвийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Б.Жавхлан, төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав нар танилцуулав.

Танилцуулга болон аудитын дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболдын тавьсан асуултад Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Харилцаа холбооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга С.Цагаанхүү нар хариулж, тайлбар хийв.

*Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн талаар Улсын Их Хурлын гишүүнээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Ж.Золжаргал:** Улсын Их Хурлын гишүүн Д.Батлутын гаргасан, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн хөрөнгө оруулалтын хавсралтын 25.1.6-д тусгагдсан төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүн, хэрэгжих хугацаанд өөрчлөлт оруулахгүйгээр хэрэгжүүлэх байршил буюу сумдын тоог цөөрүүлж, Хэнтий аймаг

/Батноров, Дадал, Баян-Адарга, Галшар, Биндэр, Баянмөнх, Дархан, Норовлин сум/, үүрэн холбооны сүлжээ оруулах, хэрэгжих хугацаа 2024-2026 он, төсөвт өртөг 2 тэрбум 924 сая 700 мянган төгрөг, 2024 онд санхүүжих дүн 877.4 сая төгрөг гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Сангийн сайд Б.Жавхлан, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 4  
Бүгд: 12  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

*Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн А.Ганбаатар Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.*

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 1 цаг 04 минут үргэлжилж, 13 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 92.3 хувийн ирцтэйгээр 16 цаг 54 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:  
ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ж.ЗОЛЖАРГАЛ

Тэмдэглэл хөтөлсөн:  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ  
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 08 дугаар сарын 20-ны өдөр,  
Мягмар гараг  
Төрийн ордон “Их засаг” танхим,  
15 цаг 50 минут

### БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Ж.Золжаргал:** Байнгын хорооны  
эрхэм гишүүдийн мэндийг хүргэе.

Тэгээд ирц 61,5 хувьтай болсон  
учраас хуралдааныг нээснийг мэдэгдье.

Чуулганы хуралдааны дэгийн  
тухай хуулийн 7.8-д заасны дагуу  
гишүүдийн ирцийг тойргоор нь  
танилцуулна гээд. 11 дүгээр тойрог  
Батиугар гишүүн ирсэн байна. 12 дугаар  
тойрог Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн,  
7 дугаар тойрог Тогтмолын Мөнхсайхан  
гишүүн, 6 дугаар тойрог  
Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн, 8  
дугаар тойрог Жигжидсүрэнгийн  
Чинбүрэн гишүүн, Чинбүрэн гишүүн  
ирцдээ орчихъё, орж ирж яваа гэж  
мэдэгдсэн учраас. Тийм. Байхгүй гишүүд  
ээ. Хэн Батиугар гишүүн, өөр хэн билээ.  
Ганбаатар гишүүн бас давхар юу гээд  
байсан тийм ээ. Батиугар гишүүн рүү  
мэдээ хүргэх үү. Тийм. Хурал эхэлж  
байгаа учраас хуралдаа ирж сууна уу  
гээд хүмүүс рүү мессеж биччихье.  
Уучлаарай энд зөрүүлж бичээд зөрүүлээд  
унижээ. Мөнхбат гишүүн 7 дугаар  
тойрог. Энэ яачхаж, харин тийм байна.  
Та хоёрынхыг сольчихсон байна,  
уучлаарай, үүнийг залруулъя.

Байнгын хорооны хуралдаанаар  
хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1 дүгээрт, нь Монгол Улсын  
Засгийн газрын 24-28 оны үйл  
ажиллагааны хөтөлбөр батлах тухай  
Улсын Их Хурлын тогтоолын төсөл,

2 дугаарт, Монгол Улсын 24 оны  
төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах  
тухай, Үндэсний баялгийн сангийн 24 оны  
төсвийн тухай хуулийн төсөл.

Эдгээр 2 асуудлыг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудал дээр нэмэлт  
саналтай гишүүн байна уу? Хэлэлцэх  
асуудал дээр нэмэлт саналтай гишүүн  
байхгүй байна.

Эхний асуудалдаа оръё.

**“Монгол Улсын Засгийн газрын  
24-28 оны үйл ажиллагааны хөтөлбөр  
батлах тухай” Улсын Их Хурлын  
тогтоолын төслийг хэлэлцье.**

Ингээд хэлэлцэх асуудлаар  
хуралдаанд оролцож байгаа албан  
тушаалтнуудыг урьж байна.

Улсын Их Хурлын гишүүн Цахим  
хөгжил, инновац, харилцаа холбооны  
сайд Баатархүү, ЗГХЭГ-ын дэд дарга  
Цолмон. Хүмүүсээ орж ирэхээр нь  
танилцуулъя даа.

Тэгээд энэ хооронд гишүүд хэрвээ  
цаг хэмнэх үүднээс зарчмын зөрөөтэй  
саналтай гишүүд байвал саналаа бичгээр  
өгөөрэй гэж хүсье.

Хэлэлцэх асуудалтай холбоотой  
хуралдаанд оролцож байгаа албан  
тушаалтнуудыг танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн, Цахим  
хөгжил, инновац, харилцаа холбооны  
сайд Баатархүү. Баатархүү сайд ирсэн  
байна. ЗГХЭГ-ын дэд дарга Цолмон.  
Хуралдаанд ирсэн албан тушаалтнууд  
Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн  
нарийн бичгийн дарга Батхүү байна уу.  
Аж үйлдвэржилтийн байнгын хороон  
дээр байгаа. ХЗДХЯ-ны Төрийн нарийн  
бичгийн дарга Мягмар. Байгаль орчин,  
уур амьсгалын өөрчлөлтийн яамны  
Төрийн нарийн бичгийн дарга Баттулга.  
Баттулга байхгүй байна. Гэр бүл,  
хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны

Төрийн нарийн бичгийн дарга Мөнхзул байхгүй байна. ЗТЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Батболд байхгүй юм байна. ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Жамбалцэрэн байхгүй байна. Энэ чинь бараг ирсэн хүмүүс нь өөрсдийгөө танилцуулчихвал болох юм биш үү. Эдийн засаг, хөгжлийн яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Балчинлуvsан байна уу. ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Очирбат байхгүй байгаа юм байна. ГХЯ-ны Америк, Ойрх Дорнод, арлын орнуудын газрын захирал Ананд, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Сонор. Ингээд энэ 2, 3 хуудас байгаа учраас үндсэн гол Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны төлөөлөл ирсэн байна.

Бусад яамны албан тушаалтнууд ирсэн байна гэж үзээд хүрэлцэн ирсэн хүмүүсээ танилцуулаагүй хүмүүс бол өөрсдөөр нь танилцуулчих уу. Тэгээд бүгдийг нь уншаад яах вэ дээ, тийм ээ. Төрийн нарийн бичгийн дарга нар ер нь байхгүй байгаа юм байна шүү дээ. Давхцаж байгаа байх тийм ээ. Тийм, хурал нь давхцаад, тэгээд бас хариуцсан хүмүүс нь ирсэн байна.

Ингээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-т заасны дагуу Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасан.

Тэгэхээр энэ тогтоолын төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Ингээд 1 дүгээрт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай тогтоолын төслийн 1 дүгээр заалттай холбогдуулан, хөтөлбөрийн 1 дүгээр хавсралтаар тийм, үйл ажиллагааны хөтөлбөр үр дүнгийн хяналт шинжилгээ үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшнийг баталсан

тухай тогтоолтой холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу?

Асуулт асуух гишүүдэд микрофон өгье. Соронзонболд гишүүн, Мөнхбат гишүүн.

Соронзонболд гишүүний микрофоныг өгье.

**Л.Соронзонболд:** Өдрийн мэнд хүргэе. Юуны, Засгийн газрын мөрийн хөтөлбөр дотроос энэ 3.3.7 дээр энэ татварын хөнгөлөлттэй чөлөөт бүс шинжлэх ухааны паркийг хөгжүүлнэ гээд ингээд заачихсан байгаа.

Тэгэхээр энэхүү чөлөөт бүс паркийг ер нь байрилын хувьд хаана гэж төлөвлөж байгаа вэ гэдэг нэг асуулт, 1 дүгээр асуулт байгаад байгаа юм.

2 дугаар асуулт болохоор бол ерөнхийдөө Монголчууд энэ цахим мөрийтэй тоглоом, энэ цахим залиланд маш ихээр өр өртөж байгаа. Тэгэхээр энэ асуудлаар ер нь мөрийн хөтөлбөрт яг ямар заалт тусаж орж байгаа вэ гэдэг ийм 2 асуулт байна.

**Ж.Золжаргал:** 1, 2 дугаар асуудлын хүрээнд Баатархүү сайд байр сууриа илэрхийлэх үү. Бас Эдийн засгийн хөгжлийн яамнаас инновацын тусгай бүсийн талаар нэмэлт мэдээлэл байвал болно. 3 номерын микрофон.

**Ц.Баатархүү:** Байнгын хорооны гишүүдэд энэ өдрийн мэндийг дэвшүүлье. Мэдээлэл технологийн үйлдвэрлэлийг дэмжих хууль өнгөрсөн парламентаар батлагдсан. Энэ хууль батлагдсантай холбогдуулаад старт ап компаниудыг ер нь бойжуулах, дэмжих ийм экосистемийг бүрдүүлье гэдэг хуулийн үндсэн агуулга байгаа. Хуулийн үндсэн агуулгын гол нэг концепц нь бага зэргийн зөрөөтэй юм уу, нэмж тайлбарлах шаардлагатай зүйл нь юу юм бэ гэхээр тэр нөгөө виртуал бүс гэж байгаа. Тэр бүс нь юу гэсэн үг юм бэ гэхээр Эдийн



засаг, хөгжлийн яам, Сангийн яам, манай яам хамтарсан журмыг Засгийн газраар батлуулаад, тэр журмын хүрээнд ямар компани гарааны компаниудыг виртуал бүсэд бүртгэх вэ гэдгээ шийднэ. Үүнийг шийдсэний дараа бол тэр виртуал бүс гэж нэрлэж байгаа нь бол заавал тэр Ай Ти парк дээр компаниуд нь, гарааны компаниуд бол ирэх шаардлага байхгүй. Баян-Өлгийд байгаа компани манай платформд бүртгэх юм бол тэндээ үйл ажиллагаагаа явуулаад, татварын хөнгөлөлт авна. Дорнод аймагт байгаа компани бол Дорноддоо үйл ажиллагаа явуулж болно гэсэн үзэл санаагаар бол тэр виртуал бүс гэдгийг бол Мэдээлэл технологийг дэмжих тухай хуулийн төсөлд оруулсан байгаа. Ийм зорилготой байгаа шүү.

Тодруулах юм байвал нэмж тодруулж асуугаарай гэж хэлье.

**Ж.Золжаргал:** 3 номерын микрофоныг нээж өгнө үү.

**Ц.Баатархүү:** 2 дахь асуудал энэ цахим залилан. Ингээд кибер аюулгүй байдалтай холбоотой цогц асуудлыг та хөндөж байна л даа. Тэгэхээр энэ кибер аюулгүй байдлыг хангах хүрээнд Монгол Улсад бол 3 том нийтийн төв, 3 том төв ажиллаж байгаа.

Төрийн байгууллагуудын кибер аюулгүй байдлыг үндсэндээ ТЕГ-ын дэргэд байдаг Серт төв үндсэнд нь цахим залилан, цахим халдлага энэ зүйлээс хамгаалдаг.

Батлан хамгаалах чиглэлийг нь бол БХЯ-ны дэргэд байдаг.

Иргэн, хувь хүн, хувийн хэвилийнхэн энэ цахим залилан, цахим хардлагад өртөхөөс сэргийлэх, урьдчилан сэргийлэх, олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй Кибер аюулгүй байдлын нийтийн төв бол Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны дэргэд бол өнгөрсөн жил бол

байгуулагдсан. Энэ нийтийн төвийн судалгаагаар бол ерөөсөө бид нар иргэдээ энэ цахим залилангаас урьдчилан сэргийлэх, танин мэдүүлэх, мэдээлэл сурталчилгаа өгөх үүрэгтэйгээр энэ бол байгуулагдсан.

Зарим нэг төрийн байгууллагуудын гаргаж байгаа веб сайтууд нууцлалаа хадгалж байна уу, иргэдийн мэдээллийг алдах эрсдэл байна уу гэдэг ийм кибер аюулгүй байдлын аудит хийлгэх ийм үүргийг хүлээж байдаг.

Тийм учраас 2025 он, 2026 оны бид нарын гол төлөвлөж байгаа ажил бол ер нь энэ Монгол Улсын хэмжээнд кибер аюулгүй байдлынхаа түвшнийг тогтоолгох хөндлөнгийн аудит бол Монгол Улс бол хийх шаардлагатай юм байна гэдэг дүгнэлтэд хүрсэн. Хаанаа цоорхой байгаа юм бэ гэдгийг бид нар оношлох хэрэгтэй юм байна лээ.

Тэгээд үүнийг бол заавал гаднын өөр байгууллагаар хийлгэх шаардлагатай. Тийм учраас үүнийг бид нар кибер аюулгүй байдлын түвшнийг тогтооно гэдэг ийм байдлаар бол үндсэн чиглэлд оруулсан байгаа. Энэ бол нөгөө жил жилийнхээ үйл ажиллагааны хөтөлбөр дээр их тодорхой тавих юм байна лээ.

2 дугаарт, нь ер нь цаг ... /минут дуусав/

**Ж.Золжаргал:** Баярлалаа. Мөнхбат гишүүний микрофоныг нээж өгнө үү.

**Ц.Мөнхбат:** Энэ өнгөрсөн жилүүдэд Цахим засаглалын тухай их ярьж байгаа. И-Монголиа гэдэг платформыг бас ажиллуулаад үүнийг хөгжүүлээд бас нэлээдгүй цаг хугацаа боллоо. Энэ дээр энэ 2024 оны байдлаар тус системийн дөрвөн нойл хувилбарыг хөгжүүлж, үндсэн 6 сувгаар төр, хувийн хэвилийн 1173 төрийн үйлчилгээг 43 сая

удаа үзүүлсэн байна гэж байна. Ер нь энэ та бүхний үзэж байгаагаар төр, хувийн хэвшлийн хэчнээн энэ үйлчилгээг бид нар цахимжуулах шаардлагатай байгаа юм бэ? Түүнээс хэд нь, одоогоор 1173 нь орчхоод байгаа юм шиг байна. Одоо хэдэн хувь нь дахиж нэмж орох ёстой юм? Үүнийг бид нар ямар хугацаанд хийх ёстой юм бэ? Энэ төрийн байгууллагуудын хоорондын уялдаанууд, ялангуяа энэ нөгөө агентлагуудын хоорондын уялдаанууд хэр энд ингээд уялдаа холбоотой явж чадаж байгаа вэ гэдэг нэг ийм асуудал асуух гэсэн юм.

2 дугаарт, энэ үндэсний хиймэл дагуулыг нэвтрүүлнэ гэж байгаа юм. Энэ үндэсний хиймэл дагуулыг ер нь хэзээ нэвтрүүлэх юм. Одоо энэ Засгийн газрын мөрийн хөтөлбөрт бол орчихлоо. Та бүгдийн судалгаагаар хэзээ нэвтрүүлнэ гэсэн ийм шаардлага байгаа юм бэ гэдгийг бас нэг асуучихъя.

3 дугаарт, энэ манай мөрийн хөтөлбөрт тусгагдсан асуудлууд дандаа нэг тийм ерөнхий, ерөнхий орчихсон байгаа юм. Тэгэхээр зэрэг энэ багийн холбоонууд, дээрээс нь энэ улсын чанарт авто зам дагасан энэ бүс нутгийн холбоожуулалтын асуудлыг, энэ интернэтжүүлэлтийн асуудал ямар түвшинд, хэдэн хувьтай байгаа вэ? Монгол орны хэмжээнд. Энэ хэзээ бүрэн гүйцэх юм. Одоо энэ үндэсний хиймэл дагуулаа хөөргөж чадах юм бол энэ бол бүрэн дүүрэн хангагдана гэсэн ийм зүйл бол энэ мөрийн хөтөлбөрт байгаа юм.

Тэгээд үндэсний хиймэл дагуулаа хөөргөх хүртэлх хугацаанд энэ наана нь энэ асуудлаа яаж шийдье гэж ингээж төлөвлөж байгаа юм. Энэ өөрөө хэдэн хувьтай байна? Ирэх он жилүүдэд өөр технологийн шийдлүүдийг бас судалж байгаа юм байна уу. Эсвэл үүрэн холбооны компаниудын тендерт орохыг нь хүлээгээд ингээд байгаа юм уу гэдэг ийм зүйлүүдийг асууя.

**Ж.Золжаргал:** Баярлалаа. Баатархүү сайдад харцулт өгөх үү? 3 номерын микрофоныг нээж өгье. 3 номерын микрофоныг нээж өгнө үү.

**Ц.Баатархүү:** Энэ маш чухал асуудлыг хөндөж байна л даа. Тэгэхээр концепцын хувьд и-Монгол дээр байгаа төрийн үйлчилгээг цахимжуулах концепцыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам бол өөрчлөх ийм санал оруулсан. Засгийн газрын хөтөлбөрт. Төр ер нь бүх үйлчилгээг өгөх нь зөв үү, буруу юу, аль үйлчилгээгээ хувийн хэвшил рүү шилжүүлэх вэ гэдэг судалгааны ажлыг эхлүүлсэн байгаа. Бид нар өмнөх жилүүдэд ер нь төрийн үйлчилгээг бүх түвшиндээ цахимжуулья гэдэг концепц явж байсан бол аль үйлчилгээгээ болих вэ гээд. Тэгээд манай агентлаг дээр бол төрийн үйлчилгээг дахин загварчлах ийм хэлтэс, газрууд бол байгуулагдсан. Эндээс үүдээд үйлчилгээг аль болохоор яаж богинохон болгох вэ, аль процессыг нь болиулах вэ, ямар үйлчилгээгээ хувийн хэвшил рүү шилжүүлэх вэ гэдэг юм явж байгаа юм. Үүний концепц нь юу юм бэ гэхээр мэргэжлийн холбооны хууль батлагдчихсан. Одоо бүх салбар бол зарим чиг үүргээ мэргэжлийн холбоонд өгөх ийм хуультай болсон.

Тэгэхээр 9 сард бол манай Мэдээлэл, харилцаа холбооны мэргэжлийн холбоо байгуулагдаад, Засгийн газраар бид нар энэ чиг үүргээр бол мэргэжлийн холбоо өгнө, үүнийг ер нь хувийн хэвшил рүү өгье, энэ үйлчилгээнүүдийг нь бол ер нь төр өгөх шаардлагагүй юм байна лээ гэдэг концепц байгаа юм.

Тэгэхээр бид нар бол төрийн үйлчилгээ дээр олон биш, төр яг ямар үйлчилгээ өгөх вэ гэдэг концепц гаргаж байгаа гэдгийг хэлье.

2 дугаарт нь, аймгууд дээр төрийн, орон нутгийн төр захиргаанаас гаргаж байгаа үйлчилгээнүүдийн



цахимжилтын түвшний судалгаа хийсэн. Аймаг болгон өөр байдаг. Жишээ нь галын дүгнэлт авч байгаа Баянхонгор аймаг 5 зүйл шаарддаг бол Хэнтий аймаг 8 зүйл шаарддаг юм байна лээ. Аймаг болгоны түвшин өөр байдаг учраас бид нар аймгууд дээр үүнийг нэг ийм түвшинд аваачих ийм чиглэл өгөөд ажиллаж байгаа гэдгийг хэлье.

Сансар судлалын холбоотой зүйл дээр бол Золбаяр дарга нэмж хариулах байх. Ер нь бол зүгээр 4 жи интернэтийн сүлжээ бол Монгол Улсын хэмжээнд 26,8 хувийг бүрхсэн байгаа. 2027 он гэхэд Монгол Улс анх удаагаа үндэсний хиймэл дагуулын сүлжээтэй болох бэлтгэл ажил хийгдэж байна. Нийтдээ бол 90 гаруй улс бол өндөр, нам, дунд орбитын түвшний хиймэл дагуултай. Монгол бол гео буюу 35 мянган км-ээс дээших ийм хиймэл дагуултай болох Засгийн газар хоорондын хэлэлцээр хийгдэж эхэлж байна. Үүнтэй холбогдуулаад бол төсвийн тодотгол дээр хиймэл дагуултай холбоотой төсөв орж ирсэн. Аягүй энгийнээр тайлбарлах юм бол иргэд Монгол Улсын нутаг дэвсгэр дээр Старлинг шиг ийм интернэтийг 2 дахин хямд үнээр бүрэн интернэттэй болох боломж бүрдэнэ гэж байгаа.

Тэгээд илүү дэлгэрэнгүйг бол манай хариуцаж байгаа Золбаяр дарга тайлбарлаад өгөөрэй.

**Ж.Золжаргал:** Золбаяр дарга. 4 номерын микрофон нээж өгнө үү.

Кибер аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны дарга. Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын тушаалаар байгуулагдсан Үндэсний хиймэл дагуул төслийн ажлыг хийж зохицуулах ажлын ажлын хэсгийн ахлагч Золбаяр байна.

Үндэсний хиймэл дагуулыг сая сайд маань ерөнхий юуг нь ярилцлаа. Монгол Улсын нийт газар нутгийн 26,8 хувь гэж байна. Үүний 73 хувийн хүн амьдрах бололцоотой хэсгүүдийг нь авч

үзэх юм бол 65 хувийн газар нутагт бид нар харилцаа холбооны ямар нэгэн сүлжээний бүрхэлтгүй ийм газар нутаг байгаа. Энэ газар нутаг бол үндэсний хиймэл дагуул төсөл хэрэгжиж, Монгол Улс үндэсний бие даасан хиймэл дагуултай болсноор энэ бүс нутагт харилцаа холбооны сүлжээ үүсэх бүрэн боломж бий болно. Өөрөөр хэлэх юм бол бид бусад дэд бүтэц дээр түрүүн бас тендерийн юунуудыг ярьж байна. Монгол Улсын 1648 багийн 150-аас бусад баг нь төвийнхөө хэмжээнд ямар нэгэн байдлаар үүрэн телефоны сүлжээнд хүрээд хамрагдчихсан байгаа. Одоо 150 баг хамрагдаагүй гэдэг судалгааг бид нар өнгөрсөн онд хийгээд Монгол Улсын 24 оны төсөв дээр 100 багийг нь шийдье гээд эхний 50-ийг нь энэ жил, үлдсэн 50-ийг нь хойтон жил шийдье гэдэг ийм байдлаар явсан.

Энэ төслийг хэрэгжүүлэх явц дээр бид төр, хувийн хэвшил хамтарсан байдлаар үүнийг хэрэгжүүлээд Монгол Улсын Засгийн газраас хөрөнгө оруулалт хийгээд, хатуу дэд бүтцийг нь байгуулах бүх нийтийн үүргийн үйлчилгээний сангаас энд ашиглалт үйлчилгээний зардлыг нь гаргах, үүрэн телефоны операторууд бол өөрийн тоног төхөөрөмжийн дунд суурилуулж ингэж хамтарсан байдлаар энэ алслагдсан сум, суурин газарт сүлжээг оруулах гэсэн энэ хөтөлбөрийг бол хэрэгжүүлээд явж байгаа. Энэ маань ингээд л явах дээр ер нь шаардлага нь ямар байдлаар үүсээд байгаа вэ гэхээр манай хөдөө орон нутагт байгаа багийн иргэд маань өвөлдөө, зундаа гээд байнгын нүүдлийн юугаар байдаг учраас яг тухайн үүрэн телефоны станцууд бүх нийтийн үүргийн сангаар ч юм уу, өөрийн хөрөнгө оруулалтаар сүлжээний бүрхэлтийг үүсгэхээр тухайн тэнд бүс нутгаас үүсэж байгаа ачааллын хэмжээ нь үүрэн телефоныхоо нөгөө бизнесийн байгууллага учраас тэд нарын зохистой хэмжээнд нь ачааллын хэмжээ орлогын хэмжээ нь хүрэхгүй байгаа учраас ийм төвлөрсөн ... /минут дуусав/

**Ж.Золжаргал:** Тодруулга  
Мөнхбат гишүүнд.

**Ц.Мөнхбат:** Тэгэхээр тэр 150 хэдэн харилцаа холбоо очихгүй байгаа багуудыг 2027 онд энэ үндэсний хиймэл дагуул хөөртөл бол асуудал шийдэгдэхгүй л гэж ойлгож болох уу.

**Ж.Золжаргал:** 3 номерын микрофон, сайдын микрофон нээж өгнө үү.

**Ц.Баатархүү:** Яг ингээд интернэтийн шилэн кабель, дээрээс нь үүрэн телефоны операторуудын хэрэглэдэг мэдээлэл дамжуулах төвүүд байдаг.

Тэгэхээр ямар нэгэн хэлбэрээр бид нар энэ интернэтийн хүрэлцээг Монгол Улсын нутаг дэвсгэр дээр бүрэн өгье гэдэг судалгаагаа бол яам гаргаад, 20 тэрбум төгрөгийг бол улсын төсөв дээр суулгасан байгаа. 10 тэрбум төгрөг нь бол өнгөрсөн одоо энэ оны буюу 24 онд тендерүүд нь зарлагдаад, ажлууд нь эхэлчихсэн явж байгаа. Зарим нэг багцын тендер бол зарлагдаад компаниуд орж ирээгүй юм байна лээ. Жишээлэх юм бол Хэнтий аймаг, жишээлэх юм бол Баян-Өлгий аймаг.

Тэгээд яагаад ингээд компаниуд орж эрхгүй байгаа юм бэ гэдэг учир шалтгааныг нь үзэхээр олон сумын нэрийг Улсын Их Хурлын гишүүд маань санал болгодог юм байна. Түүн дээр бол тендерт нь компаниуд ордоггүй юм байна л даа. Ашиггүй юм байна гэж үзээд. Одоо тэгэхээр 25 оны төсөв дээр 10 тэрбум төгрөгийн багц байгаад байгаа.

2 дугаарт, яам бол 25 оны төсөв дээр ингээд Улсын Их Хурлын гишүүдээс маш их санал ирж байгаа учраас 27 оныг хүлээхгүйгээр 25 оны төсөвт бол Их Хурлын гишүүд өөрсдөө ч Сангийн яам руу санал өгөөд, манай яам руу санал өгч байгаа учраас бид нар 10 тэрбум төгрөг

бол суучихсан байгаа. Нэмээд төсөв суулгаад ингээд энэ асуудлыг үе шаттайгаар шийдье гэсэн ийм бодлогоор ажиллаж байгаа шүү.

**Ж.Золжаргал:** Баярлалаа. Ингээд тогтоолын төслийн 1 дүгээр заалттай холбоотой асуулт асууж дууслаа.

2 дугаар заалттай холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрсээ өгнө үү. Та бүхэнд тарааж өгсөн байгаа. Энэ Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай гээд Улсын Их Хурлын тогтоолын 4 заалттай. Холбоотой ийм 4 заалттай. Тэгээд бид нар дэгээрээ заалт тус бүрээр асуулт асуух ёстой юм байна. Ингээд заалтууд маань жишээ нь 3 дугаар заалт. Жишээлбэл ингээд нэг нүүр хагас ийм зүйлс байгаа болохоор эндээс уншиж танилцуулах нь зохимжгүй байна. Та бүхэн дор бүрнээ хараад 1, 2, 3, 4 дүгээр заалттай холбоотой асуулт байвал.

Одоо 2 дугаар заалттай холбоотой асуулт байвал асууж тодруулна уу?

Би 2 дугаар заалтыг нь уншаад өгөх үү? 2 дугаар заалт. Монгол Улсын Засгийн газрын 24-28 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр ЗГ-тай үйл ажиллагаагаа уялдуулан хамтарч ажиллахыг Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын дарга нарт үүрэг болгож, тус хөтөлбөр батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар Оюун-Эрдэнэд даалгасгай.

1 дүгээрт, нь үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлыг тооцоолж, санхүүгийн эх үүсвэрийн үнэлгээ болон өрийн тогтвортой байдлын шинжилгээ хийх,

2 дугаарт, нь үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг түүнд хийх хяналт шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшний хамт баталж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах,

3 дугаарт, үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтуудыг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө болон жил бүрийн улсын төсөвт тусган хэрэгжүүлэх,

4-т нь, хэрэгжилтийг тайлагнахдаа энэ тогтоолын 2 дугаар хавсралтад заасны дагуу үнэлгээ хийх гээд,

5 дугаарт, нь улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхдээ энэ тогтоолын 2 дугаар хавсралтын үр дүнгийн тухайн оны зорилтыг хангахад чиглүүлэх гэх мэтчилэн ийм заалтууд байна.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр та бүхэнд бүгдэд тараагдсан байгаа шүү дээ. Уншиж танилцсан байх.

Тэгээд үүнтэй л холбоотой Улсын Их Хурлын тогтоолын зүйл заалтаас асуулт асууя. 2 дугаар заалт дээр асуулттай хүн байна уу? Байхгүй юу? Байхгүй. 2 дугаар дээр асуулт байхгүй гэж үзлээ.

3 дугаар заалттай холбоотой асуулттай гишүүд байвал нэрсээ өгнө үү? Чинбүрэн гишүүний микрофоныг нээж өгөхийг хүсье.

**Ж.Чинбүрэн:** Баярлалаа. Бүгдэд нь энэ өдрийн мэнд хүргэе. 3 дугаар асуудал болохоор 24-28 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтыг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө болон жил бүрийн

улсын төсөвт тусган хэрэгжүүлэх гэсэн энэ сэдэвтэй байгаа.

Тэгээд миний асуух гэж байгаа зүйл бол Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдаас бүр зориуд асууя гэж бодож байгаа зүйл бол бид өнгөрсөн парламентад нэг чухал зүйлийг ярилцсан. Энэ бол олон нийтийн мэдэх ёстой эрхийг хангаж, эмийн сонсгол хийсэн. Эмийн сонсгол дээр нэг гарсан ноцтой зөрчил юу байна вэ гэхээр эмийн талаарх үнийн мэдээлэл ард иргэдэд нээлттэй очдоггүй. Бид цахим болоод байгаа, бүх юмыг ил болгож байгаа хэдий ч гааль дээр мэдүүлж байгаа бөөний үнэ, жижиглэнгээр авч байгаа иргэдэд очиж байгаа эмийн үнийн хэд дахин нугаларч, хэд дахин өсөж очиж байгаа талаар мэдээлэл байдаггүй. Тэр ч утгаараа бас Их Хурлаас Засгийн газарт, Ерөнхий сайдад хандсан үүрэг, тогтоол гаргасан. Энэ тогтоолын тайланг бид 11 сард сонсоно. Та бүгдээс.

Тэгэхээр одоо чухал зүйл юу байна вэ гэхээр тэр гааль дээр мэдүүлж байгаа компаниудын бөөний үнийг ил болгох. Энэ дээр бол оролцогч талууд нь таны хариуцаж байгаа яамнаас гадна, ЭМЯ, тэгээд дээрээс нь Сангийн яам бүгд энэ ил тод байлгах, мэдээллийг ил тод байлгах тал дээр ямар ажлууд хийж байгаа юм. Одоо энэ төсвийн тодотголтой холбоотой та бүгдийн ажлын мөрийн хөтөлбөр дотор энэ чиглэлийн зүйлүүд орсон уу. Энэ талаар мэдээлэл байна уу, 1-д.

2-т асууя гэж бодож байгаа зүйл бол энэ эрүүл мэндийн салбарын цахим шилжилт бол үнэхээр нурсан. Өнгөрсөн парламентаар бид бас Байнгын хороо дээрээ байнга ярьж, тэр битгий хэл асуулга хүртэл тавьж ажилласан. Энд бол Дэлхийн банкны 19 сая долларын төсвөө хэрэгжүүлж чадалгүй мөнгө нь байгаад байхад алдчихсан ийм тохиолдол байгаа. Тийм ээ.

Тэгэхээр энэтэй холбоотой бас та бүхэн энэ Засгийн газрын мөрийн хөтөлбөр дотор энэ асуудлуудыг ярилцав уу? Энэ асуудлыг шийдэх тал дээр одоо ерөөсөө цахим шилжилтэд шилжиж чадаагүй байгаа ганцхан салбар эрүүл мэндийн салбар болчихсон.

Тэгээд та бүгдийн манлайлал бас чухал байна. Энэ ганцхан ЭМЯ-ны асуудал биш ЭМЯ дангаараа хийх гээд чадаагүй. Тийм учраас Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд энэ чиглэл дээр ямар бодлого барьж ажиллах вэ. Энэ талаараа тайлбар хэлж өгөөч гэж хүсэж байна.

**Ж.Золжаргал:** Баярлалаа 3 номерын микрофон. Баатархүү сайдын микрофоныг нээж өгье.

**Ц.Баатархүү:** Чинбүрэн гишүүн маш зөв асуудлыг хөндөж байна. Ер нь энэ цахим хөгжил гэдэг бол тусдаа салбар биш бүх салбарын хөгжлийн суурь шүү дээ. Тэгэхээр хамгийн их хэрэглээтэй байгаа, тэр дундаа хиймэл оюун ухааныг хамгийн их ашиглаж байгаа энэ цахим хөгжлийн хөгжил дэвшлийг ашиглаж байгаа салбар бол дэлхий даяар эрүүл мэндийн салбар болчихоод байгаа.

Тэгээд Монголд үүнийгээ хэрхэн нутагшуулах вэ гэдэг асуудал бол маш чухал байгаад байна. Бид нар ажлаа аваад судлаад үзэхэд бол 34 орчим эрүүл мэндийн чиглэлээр ажилладаг байгууллагууд код бичиж, софтвер хийсэн байна. Хамгийн гол нь эд нар маань хоорондоо интеграц байдаггүй юм байна. Холбогддоггүй. Агентлаг, газар, хэлтэс ингээд тусдаа эрүүл мэндийг цахимжуулах гээд санаачилгууд явсан байна. Гэхдээ энэ санаачилгууд бол нөгөө нэгдсэн том зургаараа хийгдээгүй учраас үүнийг интеграц хийх ажил бол чухал юм байна гэдэг саналаа бол Эрүүл мэндийн сайд Мөнхсайхан сайдтай яриад бол ажлын хэсэг гаргаад явж байгаа. Энэ дээр бол Цахим хөгжлийн яам бол кибер аюулгүй байдлын зүгээсээ ч тэр,

интеграцжуулах талаасаа ч тэр ингээд хамтарч ажиллах ийм бид 2-ын хамтарсан ажлын хэсэг гаргаж байгаа. Гараад явж байна. Ажлаа авсны дараа бол Засгийн газрын хурлаар өмнө нь хийгдэж байсан цахим эрүүл мэндийн ажлын явцыг Засгийн газрын хурал дээр тайлагнаж мэдээллээ сонсгосон. Яг таны энэ хэлж байгаа эмийн асуудал, эмийг нээлттэй болгох, энэ гааль, татварын байгууллагатай хамтарч ажиллах чиглэлээр дахиад ажлыг нь илүү тодорхой болгох ажлын хэсэг гараад 11 сард Засгийн газрын хурал дээр энэ ажлаа танилцуул гэдэг байдлаар Ерөнхий сайдаас бол чиглэл авсан.

Төсвийн тодотгол дээр ямар нэгэн нэмэлт ийм төсвийн зардал бол суулгах шаардлагагүй гэж үзээд ажил хэргийн хүрээнд яамнууд хамтарч ажиллаад үүнийгээ шийдээд явуул гэсэн. Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам, Боловсролын яам дээр бол мэдээлэл технологийн төвүүдтэй юм байна лээ. Тэр төвүүд нь бас боломжийн хэмжээнд ажилладаг юм байна. ЭМЯ ч гэсэн яг энэ цахим шинэчлэлт хариуцсан тусгай ийм баг гаргачихсан байгаа юм байна лээ. Тэгэхгүй бол энэ бас хийгдэхэд бол удааширах магадлалтай, яам хоорондын уялдааны асуудал байгаа учраас энэ ЗГХЭГ бол удаа дараа хэлээд, зөвхөн бас Цахим хөгжлийн яам хандаад санаачилга гаргахаар зарим нэр бүхий газар бол бас хөдөлж өгдөггүй юм байна лээ. Ний нуугүй хэлэхэд. Тэгээд ингээд хамтарсан ажлын хэсгүүд гаргаад явж байгаа. 11 сард сүүлийн тайланг та бүхэнд танилцуулах байх гэж бодож байна.

**Ж.Золжаргал:** Баярлалаа. Тодруулга. Чинбүрэн гишүүн тодруулга, микрофон нээж өгнө үү.

**Ж.Чинбүрэн:** Та хэд ЗГ дээр ярилцсан гэдэгт бас баяртай байна. Бас ажил хийгдэж л байгаа юм байна. Тэгээд дээрээс нь Учрал сайд байхдаа бас ЭМЯ-тай хамтарсан, бид бас нэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж өгсөн шүү дээ.



Тэнд бол ЭМЯ Цахим хөгжлийн яамтай хамтраад энэ шилжилтийг хийх үйл ажиллагааг явуулна гээд бүр заагаад өгчихсөн учраас та бүхний манлайлал их чухал шүү. Манлайлал их чухал.

Тийм учраас энэ дээрээ бүр чирч явж энэ эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн цахим шилжилтийг хийхгүй бол тэгээд энд бас өөрөө хэлж байна шүү дээ. Хэдэн компаниуд бол ийм программ софтвер хөгжүүлэлт хийж байна. Тэр бол хамаагүй. Хамгийн гол нь тэр дэд бүтцийг нь хийж өгөөд, эд нарыг интеграцжуулах тийм ээ, холбож өгөх тэр дэд бүтцийг нь л хангаж өгөхөд л та бүгдийн оролцоо маш чухал. Энэ дээр бас их шуурхай ажиллаарай гэж бас зориуд бүр захиж хэлье гэж бодлоо. Баярлалаа.

**Ж.Золжаргал:** Баярлалаа. 3 дугаар заалттай холбоотой асуулт хариулт явж дууслаа.

4 дүгээр заалттай холбоотой асуулт гишүүн байвал нэрээ өгнө үү. 4 дүгээр заалт маань бол тогтоолыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй л гэсэн заалт байгаа. Энэ дээр асуулттай гишүүн байхгүй гэж үзлээ.

Ингээд “Монгол Улсын Засгийн газрын 24-28 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

“Монгол Улсын Засгийн газрын 24-28 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан гишүүдийн бичгээр гаргасан санал байвал тухайн саналаар санал хураана. Тэгэхээр, тийм.

Тэгэхээр ийм зарчмын зөрөөтэй санал бол мөрийн хөтөлбөртэй холбоотойгоор ирээгүй байна.

Ингээд “Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Дараагийн хэлэлцэх асуудалдаа. Тийм.

Ингээд Засгийн газрын 24-28 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаар Инновац, цахим бодлогын байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Мөнхбат Төрийн байгууллагын байнгын хорооны хуралдаанд уншиж танилцуулна.

Ингээд тогтоолын төслийн хэлэлцүүлгийг хийж дууслаа. Баярлалаа.

16.24 цаг

Дараагийн асуудалдаа орёе. 2 дугаар асуудал.

**Монгол Улсын 24 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 24 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг хийнэ.**

Ингээд тайлбарыг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1-д Төсвийн болон бусад Байнгын хороо, Төсвийн зарлагын хяналтын дэд хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд нам, эвслийн бүлэг, төсвийн төслийг хэлэлцэнэ гэж, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71.2-т санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн төсвийн төслийн танилцуулгыг Монгол улсын ерөнхий аудитор төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Байнгын болон дэд хороо, нам, эвслийн бүлгийн



хуралдаанд танилцуулна гэж тус тус заасан.

Ингээд хэлэлцэх асуудлын хүрээнд асуулт хариултад оролцох албан тушаалтнууд. Асуулт асуух, хариултыг юу эхлээгүй байна.

Тэгээд ажлын хэсгийн гишүүдээс төлөөлөл албан тушаалтнууд ирсэн байгаа. Тэгэхээр түрүүний хүмүүсээс бол нэмэгдэж би орж ирсэнгүй гэж ойлгож байна. Дахиж танилцуулах шаардлагагүй болов уу.

Төсвийн тодотголтой холбоотой танилцуулга маань хэзээ эхлэх билээ. Жавхлан танилцуулна гээд ирээгүй байна шүү дээ. Одоо бид ингээд тийм, хэлэлцүүлгээсээ өмнө 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн төсвийн тухай хуулийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Болдын Жавхлан хийх ёстой.

Тэгээд аюулгүй байдлын хуралдаанд сууж байгаа учраас хүлээгдэж байгаа юм байна. Одоо хуралдааны дарааллын дагуу Сангийн сайд орж ирж төсөв танилцуулна. Дараа нь Үндэсний аудитын дүгнэлт танилцуулна. Тэгээд асуулт хариулт эхлэхээр байгаа. Тун удахгүй орж ирнэ гэж мэдээлсэн байна.

2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон Үндэсний баялгийн сангийн 24 оны төсвийн тухай хуулийн төслийн талаар танилцуулгыг Сангийн сайд Жавхлан танилцуулна.

**Б.Жавхлан:** Баярлалаа. Эрхэм Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай болон дагалдах хууль тогтоомжийн төслүүдийг 2024 оны 08 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их

Хуралд өргөн мэдүүлж, Төсвийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлсэн.

Ингээд “Хурдтай хөгжлийн төлөөх зориг” хамтарсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт үндэслэсэн 2024 оны төсвийн тодотголын төслийг боловсрууллаа. Энэхүү тодотголоор улс орны өмнө тулгарч буй сорилт, тулгамдаж буй асуудлуудыг шийдэх, эдийн засгийн өсөлтийг 5-6 ба түүнээс дээш хувьд инфляцыг нэг оронтой тоонд зээлжих зэрэглэлийг тогтвортой түвшинд хадгалах нөхцөлийг бүрдүүлэх хурдтай, зоригтой, эрс шийдвэрүүдийг гаргаж, шинэ 30 жилийн хөгжлийн гарааг эхлүүлэх хөгжлийн төслүүдийг бодитой хэрэгжүүлж эхлэх үндсэн суурийг тавьж байна.

Алсын хараа 2050, Шинэ сэргэлтийн бодлого, Монгол улсын урт дунд хугацааны хөгжлийн бодлогыг тогтвортой хэрэгжүүлж, хөгжлийн тулгамдсан асуудлыг цаг алдалгүй хурдтай шийдвэрлэхэд чиглэсэн дараах багц арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр танилцуулж байна. Үүнд:

1 дүгээрт, бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд нийслэлийн Их, Бага тойруу дахь төрийн эрх мэдлийн хэт төвлөрлийг задалж, өөдөө тэмүүлэх Монгол буюу Go-mongolia ган татлагат гүүр, Хөшгийн хөндийн туннел, Хөшгийн хөндийд төр захиргааны нэгдсэн байр, аймгийн төв, сумд болон хилийн боомтуудыг холбох Шинэ сэргэлтийн 5 тойрог, Авто замын төсөл, Шинэ Хархорин төсөл, Шинэ Зуунмод хот, Туулын хурдны зам зэрэг төслүүдийг Засгийн газрын бүрэн эрхийн хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөн бэлтгэл ажлыг хангах, ТЭЗҮ, зураг төсвийн санхүүжилтийг төсвийн тодотголд тусгалаа.

2 дугаарт, гадаад зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлж буй бүсчилсэн хөгжил Шинэ сэргэлтийн бодлогын дэд бүтэц, бүтээн байгуулалтын төсөл, арга

хэмжээний ашиглалтыг 984 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж төсвийн тодотголд тусгалаа.

3 дугаарт, 30 жил хүлээгдсэн эрчим хүчний салбарын үнэ тарифын реформыг цаг алдалгүй эхлүүлж, зах зээлийн өрсөлдөөнийг нэмэгдүүлж либералчлах хувийн хэвшил тус салбарт хөрөнгө оруулалт хийх боломжийг бүрдүүлж, салбарын санхүү, эдийн засгийн тогтвортой суурийг тавихад дэмжлэг үзүүлэх шилжилтийн үеийн зардлыг тусгалаа.

4 дүгээрт, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай болон холбогдох бусад хууль, тогтоолын төслүүд батлагдсан.

Дээрх хуулиуд батлагдсанаар зарим чиг үүрэг төсвийн ерөнхийлөн захирагч хооронд шилжсэн. Шинээр төсвийн ерөнхийлөн захирагч бий болсон. Мөн зарим яам, агентлагийн нэр өөрчлөгдсөнтэй холбогдуулан Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4-д заасны дагуу Монгол Улсын 2024 онд төсвийн тухай хуульд төсвийн зохицуулалт хийлээ.

5 дугаарт, эрдэс баялгийн салбараас төсөвт төвлөрөх орлогыг одоо ба ирээдүйн иргэдэд тэгш хүртээх хуваарилах зорилгоор Монгол Улсын Их Хурлаас энэ оны 04 дүгээр сарын 19-ний өдөр Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг баталж, Ирээдүйн өв сан, Хуримтлалын сан, Хөгжлийн сан гэсэн 3 төрөлжссөн сангаас бүрэлдэх тогтолцоог бий болгосон.

Үндэсний баялгийн сангийн төрөлжссөн сан бүрд 2024 оны төсвийн жилд эх үүсвэр төвлөрүүлэх, хуримтлал үүсгэх болон эдгээртэй холбоотой харилцааг нарийвчлан зохицуулах зорилгоор Үндэсний баялгийн сангийн

2024 оны төсвийн тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Ж.Золжаргал:** Жавхлан сайдад баярлалаа.

Холбогдох хуулийн төслүүдэд хийсэн аудитын дүгнэлтийг Монгол Улсын ерөнхий аудитор Дэлэгийн Загджав танилцуулна. 4 номерын микрофоныг нээж өгнө үү.

**Д.Загджав:** Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. Монгол Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн үр дүнгээр Монгол Улсын Засгийн газар шинэчлэн байгуулагдаж, Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон нь Төсвийн эрхлэн захирагч хооронд төсвийн зохицуулалт хийх нөхцөлийг бүрдүүлж, улс төрийн 3 намаас “Хурдтай хөгжлийн төлөөх зориг” гэрээ байгуулж, эдийн засгийн суурийг тэлэх, эрчим хүч, дэд бүтэц, аж үйлдвэржилтийн хөгжлийн томоохон төслийг хэрэгжүүлэх зорилт дэвшүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.1, 34.1.4-д заасан төсөвт тодотгол хийх шаардлагыг бий болгосон байна.

Төрийн аудитын байгууллага Монгол Улсын ЗГХЭГ-аас 2024 оны 08 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан гэж дүгнэж байна.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн 2024 оны төсвийн тодотголд тус Байнгын хороонд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсөвт нийт 97 тэрбум төгрөгийн өөрчлөлт орсон байна. Танилцуулж дууслаа.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Ж.Золжаргал:** Баярлалаа. Ингээд Монгол Улсын 24 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон Үндэсний баялгийн сангийн 24 оны төсвийн тухай хуулийн төсөл Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн талаарх товч танилцуулгыг Улсын Их Хурлын Тамгын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсээс та бүхэнд бэлтгэн хүргэсэн байгаа.

Байнгын хороо 24 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 24 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг эрхлэх асуудлынхаа хүрээнд хийнэ.

Ингээд хууль санаачлагчаас болон Байнгын хорооны өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдаас асуух асуулттай гишүүд байна уу? Асуулт байхгүй байна.

Соронзонболд гишүүнд асуулт байсан байна, уучлаарай. Соронзонболд гишүүний микрофоныг нээж өгье.

**Л.Соронзонболд:** Энэ Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын багц дээр татаас гээд байдаг юм байна шүү дээ, тийм ээ. Энэ татаас юунд зарцуулагддаг вэ гэдэг нэг асуулт байна. 2024 оны төсөв дээр 7,2 тэрбум төгрөг байх шиг байна. Татаас дээр байгаа дүн юунд зарцуулагдав гэсэн асуулт.

**Ж.Золжаргал:** 3 номерын микрофон нээж өгнө үү.

**Ц.Баатархүү:** Соронзонболд гишүүний асуултад хариулъя. Бас дэлгэрэнгүй хариултыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга хариулах байх гэж бодож байна. Ер нь зүгээр салбарын тойм өгөхөд 100 хувь татаасаар үйл ажиллагаа явуулдаг компани байгаа. Радио сүлжээ компани гэж радио телевизийн сүлжээ компани гэж үйл ажиллагаа явуулдаг компани бол татаасаар явуулдаг. Радио нэвтрүүлгийн энэ үндэсний чиг үүргийг хүлээсэн энэ компани байдаг. ХК байна. Алдагдалтай ажиллаж байгаа компани байна, ашигтай ажиллаж байгаа компани байна.

Тэгээд энэ компаниудын асуудлыг ер нь яах вэ гэхээр Засгийн газрын хурлаар бүх засаглалынх нь индексийг ингээд гаргаад, нэг мөсөн ингээд төрийн өмчит компаниудын асуудлыг Засгийн газар дээр шийднэ гэдэг утгаараа бид нар бол энэ төсвийн тодотгол дээр юм уу, төсөв дээр бол тодорхой саналуудыг өгөхгүй байгаа. ЗГХЭГ, Засгийн газрын зүгээс энэ татаасаар ажиллаж байгаа компаниудыг яах юм бэ гэдэг дээр ингээд нэгмөсөн нэгдсэн энэ ТӨК-ийн засаглалын асуудлыг ярих юм байна гэдэг ийм байдал байгаа.

Тэгээд дэлгэрэнгүй хариултыг нь Санхүү, төрийн сангаас өгчхөөрэй.

**Ж.Золжаргал:** Гишүүд асуулт хариулж, хариулт авлаа. Та товч дараагүй, тийм ээ. Нэмэлт 2 минут өгье, 3 номерт. 4 номерын микрофон.

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Харилцаа холбооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Цагаанхүү гишүүний асуултад хариулъя.

Татаас хэлбэрээр Монгол Улсын төр радио болон телевизийн мэдээллийг улсад бол үнэгүй хүргэх ёстой. Тэр үүднээсээ Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ-т радиог Монгол орон

даяар, телевизийг Монгол орон даяар үнэгүй дамжуулдаг байгаа. Түүний татаас төлбөр байгаа.

**Ж.Золжаргал:** Соронзонболд гишүүн хариултаа авсан уу?

Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авлаа.

Одоо Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан зарчмын зөрөөтэй санал гаргах гишүүн байна уу?

Зарчмын зөрөөтэй саналыг урьдчилаад бичгээр авч байгаа. Авсан байгаа. Ингээд зарчмын зөрөөтэй саналын хувьд албан бичгээр нэг санал ирсэн. Улсын Их Хурлын гишүүн Идэрбатаас 2024 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн 03/1661 тоотой ийм бичиг ирүүлсэн байна. Би үүнийг та бүхэндээ уншиж танилцуулъя.

Хүсэлт уламжлах тухай. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн хөрөнгө оруулалтын хавсралтын 25.1.6-д тусгагдсан төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхэд үүрэн холбооны сүлжээг 1 сумд байршуулах төсөвт өртгийн дүн нэмэгдсэнтэй холбоотойгоор уг төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүн, хэрэгжих хугацаанд өөрчлөлт оруулахгүйгээр хэрэгжүүлэх байриил буюу сумдын тоог цөөрүүлж, төсөл, арга хэмжээний нэрийг доор дурдсанаар өөрчлөн Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуульд тусгаж өгөхийг Танаас хүсье. Үүнд:

Үүрэн холбооны сүлжээ Хэнтий /Батноров, Дадал, Баян-Адарга, Галиар, Биндэр, Баянмөнх, Дархан, Норовлин сум/, хэрэгжих хугацаа 2024-өөс 26. Төсөвт өртөг 2 тэрбум 924 сая 700 мянган төгрөг, 2024 онд санхүүжих дүн 877,4 сая төгрөг. Хавсралт нэг хуудас

гээд зарчмын зөрөөтэй санал дээр гарын үсэг зурсан. Улсын Их Хурлын гишүүн Идэрбат гэсэн байна.

Тэгээд энэ саналын хүрээнд Сангийн сайд Болдын Жавхлан болон Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Цэндийн Баатархүү нараас тодруулга авъя. Зарчмын зөрөөтэй саналын талаар байр суурь сонсьё гэж бодож байна.

Үндсэндээ бол төсөв өөрчлөгдөхгүй, хугацаа өөрчлөгдөхгүй, өртөг, үнэ нэмэгдсэн учраас сумдын тоог цөөрүүлж байгаад ажлаа хийе л гэсэн ийм л санал ирж байгаа юм байна.

3 номер, 3 номерын микрофон нээж өгнө үү.

**Ц.Баатархүү:** Энэ нөгөө багуудыг үүрэн телефон, нөгөө интернэтээр хангах энэ нөгөө төсөв дээр сумдынхаа тоог Их Хурлын гишүүд маань их олон өгчихөөр орох компани олдохгүй байгаа учраас сумынхаа тоог өөрчилж л гэж байгаа. Тендерээ сонгон шалгаруулалт хийлгэхийг нь орон нутаг руу нь ер нь бол өгчихсөн байгаа. Хэнтий аймаг өөрөө бол сонгон шалгаруулаад явчих юм.

Тэгэхээр сумынх нь тоог цөөхөн болгоод өгөх нь бол зөв юм байна лээ. Тэгэхгүй бол энэ ажил бол явагдахгүй юм байна лээ, угаасаа. Орох компани олдохгүй, бүх компанид санал тавиад ч нэмэргүй. Тэгэхээр Идэрбат гишүүний зарчмын санал бол бид зөв өө гэж үзэж байгаа. Ажлаа явуулах талдаа.

**Ж.Золжаргал:** Баярлалаа. Жавхлан сайдын микрофоныг нээж өгье.

**Б.Жавхлан:** Үгүй, яах вэ, тэгэхдээ санхүүжих дүн өөрчлөгдөхгүй ч гэсэн энэ чинь цаанаа ингээд зарлачихсан, хүлээлт үүсчихсэн байгаа шүү, сумууд дээрээ. Тэгээд тэрийгээ яг зөв ойлгуулаад ингэх юм бол яг л салбарын л асуудал л даа. Үүнийг чинь бол яах вэ, ингээд нөгөө



багцалж байгаад сайд өөрөө сумынхаа тоонуудыг тавиад ингээд, тэгээд орон нутаг руу нь шилжүүлчихдэг учраас та л шийднэ, зүгээр.

Тэгээд одоо энэ удаа сумын тоог нь цөөлж байгаа ч гэсэн хойтон тэгээд л тэр дээр нь буцаагаад тавина. Хоёулаа буцаагаад л өрөнд орно л гэсэн үг шүү дээ. Тийм.

**Ж.Золжаргал:** Учрал сайдад микрофон нээж өгнө үү.

**Н.Учрал:** Өнгөрсөн жил энэ 150 баг дээр үүрэн холбооны сүлжээ оруулах гээд нэг 10 тэрбум төгрөгийн төсөв тавьсан. Тэгээд энэ нөгөө нэг 50 хувь нь улсын төсвөөр, 50 хувь нь нөгөө оператор компаниудын дэмжлэгтэйгээр гээд ингээд нэг ийм хамтарсан хэлбэрээр зохион байгуулъя гээд 150 баг дээр сүлжээ тавьсан боловч яг ингээд тендер зарлахаар бараг талд нь нэг ч компани орж ирээгүй. Нэг ёсондоо нэг багт бараг 100, 200 хүн хүрэхтэй үгүйтэй газар, яг ийм дэд бүтэц байгуулаад, тэгээд нөгөө ашиглалтынх нь үйлчилгээг нь хариуцаад, тэгээд интернэт оруулна гэдэг бол үнэхээр боломжгүй болсон юм билээ.

Тийм ч учраас яг үнэхээр ингээд малчин айл өрх болгонд, баг бүрд бараг малчдын өвөлжөө, хаваржаа дээр шилэн кабель татаад интернэт оруулна гэх юм бол бид судалгаа хийхэд 28 их наяд төгрөг хэрэгтэй байгаа байхгүй юу. Тийм. Тэгэхээр зайлиггүй нөгөө үндэсний хиймэл дагуултай болохоос өөр сонголт бол бидэнд үлдээгүй.

Тийм учраас энэ үндэсний хиймэл дагуулын төслийг энэ тэр Монгол талын 15 хувийн санхүүжилтийг энэ оны төсвийн тодотгол дээр суулгаж өгч байгаа юм. Ингэсний үр дүнд бид нар газрын 4 станцтай болно. Тэгээд бид улс орныхоо хаана ч интернэттэй болох бололцоо бүрдэнэ. Үгүй бол ирэх жил ч гэсэн дахиад л 150 баг яригдана. Тэгээд яаж ч зарлаад дахиад л компани орж

ирэхгүй. Тэр чинь нөгөө компаниуд ашиггүй юм чинь угаасаа орж ирэхгүй шүү дээ.

Тэгээд мөнгийг нь нэмээд байдаг, нэмээд байдаг, тэгээд орж ирдэггүй. Тэгээд хэн ашиглалтыг нь хариуцах вэ гэдэг асуулт бас байгаа. Тийм учраас энэ үүрэн холбооны сүлжээг улс орон даяар явуулахад хиймэл дагуултай болох нь хамгийн зөв гарц байна. Тэр бусад гишүүдийн яриад байгаа шиг тэр Старлингийн төхөөрөмжөөр мянга хангаад бид нар тэр зардал, мөнгийг төлөөд малчин айл өрхүүд интернэт холбогдоно гэж бол байхгүй шүү дээ.

Дээрээс нь тэр старлинг чинь нөгөө хил орчмын орон зайд ашиглагдахгүй байгаа шүү дээ. Тэр чинь геополитикийн асуудал байхгүй юу. Тийм учраас Старлингийг зөвшөөрдөггүй. Тийм учраас бид нар тэр үндэсний хиймэл дагуулын төслийг төсвийн тодотголоор тавиад байгаа нь яг ийм учиртай.

Тийм учраас бас гишүүдийг энэ үндэсний хиймэл дагуулын төслөө дэмжиж өгвөл цаашидаа бид бол улс орныхоо хаана ч интернэттэй болно. Интернэтийн хурдыг ашиглаад тэр Ай Өү Ти гэж яриад байгаа, юмсын интернэт ашиглаж энэ хотынхоо түгжрэлийг шийдэх бүх л зүйлд энэ чинь маш том дэмжлэг болно шүү гэдгийг хэлье.

**Ж.Золжаргал:** Баярлалаа. Энэ хиймэл дагуулын талаар бас Учрал сайдыг орж ирэхээс өмнө асуулт яваад тодруулга яасан байгаа. Нэмэлт мэдээлэл авлаа.

Энэ саяын зарчмын зөрөөтэй саналын хүрээнд тодруулга авлаа.

Тэгэхээр энэ саналын хүрээнд санал хураая. Идэрбат гишүүний өөрийнх нь томъёолсноор бол үүрэн холбооны сүлжээ төсөл, арга хэмжээний нэр



өөрчлөх гэдэг томъёоллоор. Тэгээд төсвийн хэмжээг нэмэгдүүлэхгүй, 24 онд нэгэнт төлөвлөсөн ажлаа гүйцэтгэе гэсэн.

Жавхлан сайдад микрофон өгье. Жавхлан сайдын микрофоныг нээж өгнө үү.

**Б.Жавхлан:** Цахим яамны Хөрөнгө оруулалтын газрын дарга нь байгаа юу. Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга нь байна уу, та юу. Дэлгэрмаа дарга аа, үүнийгээ ингэж хянах ёстой шүү. Одоо энэ чинь хэдэн сум байж байгаад хэд болох гэж байгаа юм. Тийм л дээ. Харин хэдэн сум нь хэд болох байгаа юм. Тийм, тэгэхдээ хар аа, ингэх ёстой шүү. Одоо байгаа тавигдчихсан төсөв нь яг бүтнээрээ 12 сумдаа зориулагдсан байгаа юу тийм ээ.

Тэгэхээр наадах чинь нэг сумд тавигдах төсөл нь төсөвт өртөг нь нэмэгдэнэ гэсэн үг шүү дээ. Тэгээд тэрийгээ бас хянах хэрэгтэй шүү. Төсөвт өртөг нь наадах чинь нэмэгдэхгүй гэж байгаа боловч яах вэ, нийт дүнгээрээ тэгж харагдаж байгаа боловч, задлахаар төсөвт өртөг нь нэмэгдээд явчихна.

Тэгэхээр бусад өөр аймгууд руу бас наадах чинь нөлөөлөх вий. Тийм. Тэгэхээр наадах чинь бас осолтой шүү. Тийм. Тэгээд түүнийг шалгаж байж болохгүй бол наадах чинь хамаагүй болохгүй шүү. Тийм.

Тэгээд саяынхаа бас хиймэл дагуултайгаа бас уялдуулах хэрэгтэй. Хэрвээ хиймэл дагуулаа хойтон хөөргөчихнө, ингээд болчихно гэх юм бол нэг хэдэн одоо 100 сум тэгээд одоо хүртэл болоод л байгаа юм чинь тэгээд 1 аргалаад нэг жил тэсэхэд болохгүй юм бас байхгүй шүү дээ.

Үгүй, үгүй, тэгэхдээ ийм байхгүй юу. Одоо тэр бас 2 сум чинь хойшиллоо гэхэд хойтон сайн. Одоо энэ нэг сумд

оногдож байгаа төсөвт өртөг нь нэмэгдэж байгаа тэр хэмжээгээр нэмэгдэхээр бол тэгж болохгүй. 8 сум болоод хэмнэгдэж байгаа бол болно. 12 сумынхыг 8 сумд хувааж өгөх гэж байгаа бол наадах чинь бас болохгүй шүү.

**Ж.Золжаргал:** Ингээд Сангийн сайд болон салбарын сайдын анхааруулгыг сонслоо.

Тэгэхээр албан бичгээр ирсэн саналынхаа хүрээнд санал хураалтаа явуулъя. Төсвийн байнгын хороо дээр энэ дахиад яам дээр бас яаж гүйцэтгэх вэ гэдэг нь яригдах байх.

Саналын томъёоллыг танилцуулъя.

Төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжүүлэх дүн, хэрэгжих хугацаанд өөрчлөлт оруулахгүйгээр хэрэгжүүлэх байршил, сумдын тоог цөөрүүлж доор дурдсанаар өөрчлөх:

Үүрэн холбооны сүлжээ сайжруулах Хэнтий /Батноров, Дадал, Баян-Адарга, Галиар, Биндэр, Баянмөнх, Норовлин 8 сум/ гэсэн байна.

Энэ саналыг дэмжих гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Байнгын хороодын гишүүдийн 66,7 хувиар санал дэмжигдсэн байна.

Ингээд санал хураалт явуулж дууслаа.

Төсвийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулсан талаар Инновац, цахим бодлогын байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ганбаатар Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулна.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны

*төсвийн тухай хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа.*

*Та бүхэндээ баярлалаа.*

*2 дахь хэлэлцүүлгийг явуулж дуусаад түрүүн алх тогшсон шүү. 2 дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа.*

*16.54 цаг*

*Байнгын хорооны хурал дууссаныг мэдэгдье.*

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ*

*П.ОЮУНГЭРЭЛ*